



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайхан сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/67/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он	Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70642580 Цахим хаяг: Ankhubayrd@audit.gov.mn
	Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
	Ахлах аудитор: Г.Намчинсүрэн Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	2
1. Аудитын санал дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт.....	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт.....	17
4.3 Албан шаардлага.....	17
4.4 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

1.Аудитын санал дүгнэлт



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 109
танай _____ ны № _____ т

САЙХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
С.ЛУВСАНЦООДОЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайхан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

D:/bichighereg/2022A4toot

006020194

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	42,996,353.38	28,687,496.20
33	АВЛАГА	8,556,375.73	15,280,170.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	11,947.73	-
335	Бусад авлага	8,544,428.00	15,280,170.00
3351	Байгууллагаас авах авлага	2,798,130.00	9,533,872.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,746,298.00	5,746,298.00
35	БАРАА МАТЕРИАЛ	16,439,977.65	7,833,926.20
351	Түүхий эд материал	1,758,058.20	937,243.20
35110	Тусгай зориулалттай материал	1,758,058.20	937,243.20
354	Хангамжийн материал	10,621,919.45	2,836,683.00
35410	Бичиг хэргийн материал	493,180.00	-
35420	Аж ахуйн материал	9,600,739.45	2,836,683.00
35430	Сэлбэг хэрэгсэл	528,000.00	-
35600	Мал амьтад	4,060,000.00	4,060,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	18,000,000.00	5,573,400.00
36300	Тэжээлийн нөөц	18,000,000.00	5,573,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,192,694,203.60	1,171,708,038.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,192,694,203.60	1,171,708,038.00
392	Биет хөрөнгө	1,192,427,953.53	1,169,593,037.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,049,997,186.03	1,065,853,865.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	(205,501,698.94)	(242,407,731.46)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	234,870,132.00	234,870,132.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(166,990,059.70)	(178,614,409.66)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	100,096,822.33	130,393,736.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	(35,395,982.19)	(48,607,912.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,518,277.76	47,937,160.21
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,599,562.93)	(14,627,054.42)
39209	Зам, гүүрийн байгууламж	133,304,200.00	133,304,200.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(38,274,359.57)	(43,836,314.21)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	20,176,300.00	20,176,300.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	74,262,638.33	74,262,638.33
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,035,939.59)	(9,111,571.44)
393	Биет бус хөрөнгө	266,250.07	2,115,000.10
39301	Програм хангамж	550,000.00	2,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(283,749.93)	(534,999.90)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,235,690,556.98	1,200,395,534.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,300,000.00	54,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,300,000.00	54,000.00
413	Өглөг	3,300,000.00	54,000.00
4136	Бусад өглөг	3,300,000.00	54,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	3,300,000.00	54,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,232,390,556.98	1,200,341,534.20
51	Засгийн газрын хувь оролцоо	1,232,390,556.98	1,200,341,534.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	612,751,072.17	612,751,072.17
51101	Өмч: - төрийн	612,751,072.17	612,751,072.17
512	Хуримтлагдсан үр дүн	134,448,550.09	102,399,527.31
51210	Өмнөх үеийн үр дүн	134,448,550.09	134,448,550.09

51220	Тайлант үеийн үр дүн	-	(32,049,022.78)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	485,190,934.72	485,190,934.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,235,690,556.98	1,200,395,534.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	471,338,677.57	483,982,615.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,642,429.57	56,651,429.00
120	Нийтлэг татварын бус орлого	14,522,429.57	56,651,429.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,522,429.57	56,651,429.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,186,949.00	10,799,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,335,480.57	45,852,429.00
122	Тусламжийн орлого	120,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	120,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	456,696,248.00	427,331,186.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	344,333,451.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	344,333,451.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	112,362,797.00	18,718,186.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,419,772.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,839,385.00	8,238,388.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,103,640.00	5,479,798.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	408,613,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	408,613,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	540,803,972.30	516,813,637.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	540,803,972.30	516,813,637.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	520,028,363.39	475,090,215.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	225,264,997.18	239,860,907.00
210101	Үндсэн цалин	225,264,997.18	239,860,907.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,181,135.18	30,518,844.04
210201	Тэтгэврийн даатгал	19,705,122.64	22,387,845.59
210202	Тэтгэмжийн даатгал	2,301,870.17	2,218,442.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,825,783.33	1,775,041.76
210204	Ажилгүйдлийн даатгал	395,301.50	376,137.92
210205	Эрүүл мэндийн даатгал	3,953,057.54	3,761,376.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,913,488.00	42,441,118.00
210301	Гэрэл, цахилгаан	3,926,388.00	8,032,859.00
210302	Түлш, халаалт	25,987,100.00	34,408,259.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,737,751.00	28,770,538.00
210401	Бичиг хэрэг	2,757,890.00	3,594,820.00
210402	Тээвэр, шатахуун	21,440,410.00	19,873,568.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,346,800.00	1,079,540.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	653,450.00	1,606,160.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	134,000.00	2,616,450.00

Сайхан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210408	Бараа материал акталсны зардал	3,105,201.00	-
2105	Нормативт зардал	4,590,000.00	5,036,450.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	-
210502	Хоол, хүнс	4,440,000.00	2,481,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,554,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,453,000.00	5,837,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	396,000.00	69,000.00
210604	Урсгал засвар	35,057,000.00	5,768,000.00
2107	Томилолт, зочны зардал	20,398,800.00	3,500,000.00
210702	Дотоод албан томилолт	20,398,800.00	3,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,371,500.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,371,500.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,117,692.03	119,125,358.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,802,427.00	46,466,717.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,295,265.03	72,658,641.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,775,608.91	41,723,422.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,697,500.00	29,641,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,497,500.00	27,791,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,200,000.00	1,850,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,042,908.91	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,042,908.91	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	11,467,227.69
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	11,467,227.69
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	35,200.00	614,595.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,200.00	614,595.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(69,465,294.73)	(32,831,022.78)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,501,499.63	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,948,861.30	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	13,552,638.33	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(15,501,499.63)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(84,966,794.36)	(32,831,022.78)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /	
					Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	612,751,072.2	488,208,526.5	137,840,008.7		1,238,799,607.3
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	3,017,591.8		3,017,591.8
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	612,751,072.2	488,208,526.5	140,857,600.5	-	1,241,817,199.1
C04	Үндсэн хөрөнгийн дахин	-	(3,017,591.8)	-		(3,017,591.8)

	үнэлгээний өсөлт					
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(6,409,050.4)		(6,409,050.4)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	612,751,072.2	485,190,934.7	134,448,550.1	-	1,232,390,557.0
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	612,751,072.2	485,190,934.7	134,448,550.1	-	1,232,390,557.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	612,751,072.2	485,190,934.7	134,448,550.1	-	1,232,390,557.0
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(32,049,022.8)		(32,049,022.8)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	612,751,072.2	485,190,934.7	102,399,527.3	-	1,200,341,534.2

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	476,405,397.00	440,928,316.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,186,949.00	2,798,130.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,186,949.00	2,798,130.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,186,949.00	2,798,130.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,186,949.00	2,798,130.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	475,218,448.00	438,130,186.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	344,333,451.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	344,333,451.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	130,884,997.00	29,517,186.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,419,772.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,839,385.00	8,238,388.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,625,840.00	16,278,798.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	408,613,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	408,613,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	471,801,797.00	439,310,316.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	471,801,797.00	439,310,316.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	448,228,058.09	388,053,021.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	225,264,996.91	239,794,958.27
210101	Үндсэн цалин	225,264,996.91	239,794,958.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,193,083.18	30,518,845.04
210201	Тэтгэврийн даатгал	19,717,070.64	21,631,430.41
210202	Тэтгэмжийн даатгал	2,301,870.17	2,400,588.75

210203	ҮОМШӨ-ний даатгал	1,825,783.33	1,920,670.74
210204	Ажилгүйдлийн даатгал	395,301.50	414,923.36
210205	Эрүүл мэндийн даатгал	3,953,057.54	4,151,231.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,913,488.00	42,441,118.00
210301	Гэрэл, цахилгаан	3,926,388.00	8,032,859.00
210302	Түлш, халаалт	25,987,100.00	34,408,259.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,187,050.00	20,029,080.00
210401	Бичиг хэрэг	3,369,490.00	3,078,590.00
210402	Тээвэр, шатахуун	21,170,760.00	15,870,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,346,800.00	1,079,540.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	-
2105	Нормативт зардал	4,590,000.00	4,936,450.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	-
210502	Хоол, хүнс	4,440,000.00	2,481,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,454,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,515,013.00	4,506,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	704,513.00	-
210602	Тавилга	1,840,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	700,000.00	169,000.00
210604	Урсгал засвар	38,270,500.00	4,337,250.00
2107	Томилолт, зочны зардал	20,398,800.00	3,500,000.00
210702	Дотоод албан томилолт	20,398,800.00	3,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,141,150.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,141,150.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,024,477.00	42,326,320.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,024,477.00	42,326,320.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,573,738.91	51,257,294.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,697,500.00	29,641,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,497,500.00	27,791,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,200,000.00	1,850,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,042,908.91	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,042,908.91	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	12,081,822.69
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	12,081,822.69
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,833,330.00	9,533,872.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,833,330.00	9,533,872.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,603,600.00	1,618,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,443,600.00	2,400,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,443,600.00	2,400,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,443,600.00	2,400,000.00
222001	Тоног төхөөрөмж	6,443,600.00	2,400,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(6,443,600.00)	(2,400,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(1,840,000.00)	(782,000.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны / төгрөгөөр /	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	413,419,040.00	398,313,177.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	413,419,040.00	396,213,177.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	382,367,440.00	366,571,577.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	246,640,400.00	239,361,460.27
210101	Үндсэн цалин	246,640,400.00	239,361,460.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,296,400.00	30,464,657.04
210201	Тэтгэврийн даатгал	23,430,800.00	21,577,242.41
210202	Тэтгэмжийн даатгал	2,466,400.00	2,400,588.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,973,100.00	1,920,670.74
210204	Ажилгүйдлийн даатгал	493,300.00	414,923.36
210205	Эрүүл мэндийн даатгал	4,932,800.00	4,151,231.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,738,300.00	40,725,960.00
210301	Гэрэл, цахилгаан	6,537,600.00	6,317,701.00
210302	Түлш, халаалт	34,200,700.00	34,408,259.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,194,740.00	15,042,330.00
210401	Бичиг хэрэг	3,090,600.00	2,698,590.00
210402	Тээвэр, шатахуун	11,388,000.00	11,427,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	916,140.00	916,140.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,800,000.00	-
2105	Нормативт зардал	500,000.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4,337,250.00
210604	Урсгал засвар	-	4,337,250.00
2107	Томилолт, зочны зардал	4,978,600.00	1,380,000.00
210702	Дотоод албан томилолт	4,978,600.00	1,380,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,100,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,100,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,919,000.00	34,759,920.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,919,000.00	34,759,920.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,051,600.00	29,641,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,051,600.00	29,641,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,791,600.00	27,791,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,260,000.00	1,850,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	2,100,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	2,100,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	2,100,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	390,050,000.00	408,613,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	388,750,000.00	408,613,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	388,750,000.00	408,613,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,300,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,300,000.00	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	229,393,507.00	21,781,444.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,514,660.00	21,481,444.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,514,660.00	21,481,444.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	433,498.00
210101	Үндсэн цалин	-	433,498.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	54,188.00
210201	Тэтгэврийн даатгал	-	54,188.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	1,715,158.00
210301	Гэрэл, цахилгаан	-	1,715,158.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	4,986,750.00
210401	Бичиг хэрэг	-	380,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	4,443,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	163,400.00
2105	Нормативт зардал	-	4,436,450.00
210502	Хоол, хүнс	-	2,481,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,954,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	169,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	169,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	2,120,000.00
210702	Дотоод албан томилолт	-	2,120,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,229,789.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,229,789.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,284,871.00	7,566,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,284,871.00	7,566,400.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,900.00	9,533,872.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	9,900.00	9,533,872.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	194,868,947.00	300,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	194,868,947.00	300,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	300,000.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	194,868,947.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	234,229,936.00	29,517,186.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	234,229,936.00	29,517,186.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	229,393,507.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,836,429.00	8,238,388.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	16,278,798.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сайхан сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сайхан сумын ЗДТГ нь Төрийн үйлчилгээг иргэдэд тэгш, хүртээмжтэй хүргэх эвсэг, чадварлаг, мэргэшсэн хамт олныг бүрдүүлэн, орон нутгаа хөгжүүлэх, орон нутгийн онцлогт тохирсон хөгжлийн бодлого боловсруулан, хэрэгжүүлж иргэдийн итгэлийг хүлээсэн манлайлагч захиргааны байгууллага болох, тухайн ондоо оновчтой төлөвлөлт хийж, гүйцэтгэлийн үр нөлөө, бүтээмжийг дээшлүүлж, сум орон нутгийнхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийн тогтвортой ахиулах замаар иргэдийнхээ хөгжих боломжийг хангаж, амьдрах таатай орчин бүрдүүлэхэд чиглэн, төрийн үйлчилгээг стандартад нийцүүлэх чанартай хүргэнэ гэж зорилтоо тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль -Хүчингүй болж, шинэчлэн найруулагдсан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журмын дагуу Байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузель сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардал 556,304.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,344.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 6,258.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сайхан сумын Засаг даргын тамгын газар нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,986.2 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			

Авлага	8,556.4	15,280.1	6,723.7
Урьдчилгаа			-
Бараа материал	34,440.0	13,407.3	(21,032.7)
Үндсэн хөрөнгө	1,192,694.2	1,171,708.0	(20,986.2)
Нийт хөрөнгө	1,235,690.6	1,200,395.4	(35,295.1)
Өр төлбөр	3,300.0	54.0	(3,246.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,232,390.5	1,200,341.5	(32,049.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,235,690.5	1,200,395.5	

Авлага дансны үлдэгдэл 15,280.1 мянган төгрөг болж мянган 6,723.7 мянган төгрөгөөр өссөн нь төрөөс хөнгөлөлт үзүүлсэн усны орлого оны эцэст санхүүжилт ирж төсөвт төвлөрснийг авлагаар тусгасан нь шалтгаалжээ.

Авлага дансы үлдэгдэлд 2019,2020 онд үүссэн 5,746.3 мянган төгрөгийн “Хангайн гурил” ХХК-иас авах тэжээл, хувь хүнээс авах өвсний авлага байгаагаас барагдах боломжгүй эрсдэлтэй 2,167.2 мянган төгрөгийн авлага байна.

Энэ нь “ Хангайн гурил” ХХК-ий удирдлагууд удаа дараа солигдсон тус ХХК үйл ажиллагаа явуулахгүй байгаатай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 13,407.3 мянган төгрөг болж 21,032.7 мянган төгрөгөөр буурсан нь зарим нэг үндсэн хөрөнгийн шинжтэй бараа материалыг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлсэн боон ашиглахгүй байгаа бараа материалыг акталсанаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 2008-2020 онд худалдаж авсан ашиглалтгүй мянган төгрөгийн 3,524.601 мянган төгрөгийн бараа материал байна.

Энэ нь балансийн үнийг үр дүнгүйгээр өсгөж харуулж байна. Оны эцэст 4,200.0 мянган төгрөгийн өвсний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,171.7 мянган төгрөг болж 20,986.2 мянган төгрөгөөр өссөн нь 2021 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгө мөн амйгийн Байгаль хамгаалах сангаас суманд гаргасан худаг зэргийг орлого авсан, тайлант оны хөрөнгийн элэгдэл бодогдсон нь шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар ОНХС-аас 45,852.4, урсгал төсвийн худалдан авалтаар 2,400.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 15,856.7 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансанд үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 3,418.8 мянган төгрөг, акталсан үндсэн хөрөнгө байхгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 54.0 мянган төгрөг болж 3,246.0 мянган төгрөгөөр буурсан нь иргэн Л.Баяржаргалд өгөх байсан өвсний үнийг олгосон бөгөөд 54.0 мянган төгрөг албан хаагч Д.Цэцэгмаагаас гар утасны суутгал мөнгө суутгаж авсан боловч шилжүүлээгүй үлдсэн зэрэг шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,200,341.5 мянган төгрөг болж 32,049.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үр дүнтэй холбоотой байна.

Байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 41,582.8 мянган төгрөгөөр буюу 50 хувиар буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 449,908.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс хэмнэлтийн горим хэрэгжүүлж 36,489.2 мянган төгрөгөөр бууруулан 413,419.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 413,419.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 388,750.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 59,858.3 мянган төгрөгийг оны эхний үлдэгдлээс, 1,300.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 356,741.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 782.0 мянган төгрөг, оны эхний үлдэгдлээс 19,863.0 мянган төгрөг нийт 410,395 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 398,313.2 мянган төгрөгийг зарцуулж 12,081.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс 5,000.0, стастиктикийн хэлтэсээс 858.0, үндсэн үйл ажиллагаанд 19,076.9, ХХААГ-с 8,238.2, нийт 35,113.5 мянган төгрөгний орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 32,315.3 мянган төгрөгийг зардалд зарцуулж 2,798.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

3.8 Аудитын гол асуудал

Сайхан сумын ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 117 мэдээлэл оруулахаас 117 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 1 мэдээллийн хугацаа нь болоогүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийлээ. Үүнд:

- Шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн;
- Тайлант онд тавилга хэрэгслийн зардалд 4,440.0, гар бөмбөгийн тэмцээнд 90.0, үзэсгэлэн худалдаанд 1,515.3 нийт 6,045.3 мянган төгрөгийг зарцуулсан, төсвийн хэмнэлт үүсгээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.4, 1.6, 1.7 дэх заалттай нийцээгүй;
- Байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөөгүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журам”-тай нийцээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 289,360.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 70,565.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 705.5

мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүлснээс НББ-ийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллах 1 зөвлөмж, засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 75 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчилд хүргүүлсэн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллах, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 31,961.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 10,500.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,385.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11,898.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 6,177.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Бараа материалын зардлын дансны мал амьтад дансанд 10,500.0 мянган төгрөгийн ногоон тэжээл бүртгэж зардлыг ангиллыг буруу илэрхийлсэн алдааг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Засаг даргын нөөц хөрөнгөөс нийт 3,385.7 төгрөгийг холбогдох журамд нийцэхгүй зардалд зарцуулсан нь Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 1.1 дэх заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн ба зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байгаа зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

- Тайлант онд тавилга хэрэгслийн зардалд 4,440.0, гар бөмбөгийн тэмцээнд 90.0, үзэсгэлэн худалдаанд 1,515.3 нийт 6,045.3 мянган төгрөгийг зарцуулсан, төсвийн хэмнэлт үүсгээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.4, 1.6, 1.7 дэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.
- Цалингийн зардлаас цалингийн урьдчилгааг цалингийн өглөг дансанд давхар бичилт хийгээгүй шууд зардалд 1,759.4 мянган төгрөгийг бичсэн дансны бичилтийн алдаа илэрсэн нь санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.
- Харилцагч байгууллагаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын 4,094.1 мянган төгрөгийн баримтыг аваагүй /цахим Е баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/, харилцагч байгууллагуудаас 10 дээш гүйлгээ хийсэн харилцагч байгууллагуудыг түүвэрлэн тулгахад тооцооны үлдэгдлийг баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2 заалтуудтай

бүрэн нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Засгийн газрын 2018 оны тогтоолыг зөрчин 2 орон тоог илүү баталж гүйцэтгэлээр 1 орон тоогоор дутуу буюу нийт 6177.0 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" тухай заалт, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох хуулийн заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сайхан сумын ЗДТГ	10	49,561.8	1	10,500.0	3	2,029.8	4	33,087.2	3	3,944.8